



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/14

Улаанбаатар хот

Гэр хорооллыг орон сууцжуулах
төслийг хэрэгжүүлэх талаар авах
арга хэмжээний тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 24/33 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Нийслэл хотын гэр хорооллыг орон сууцжуулах, шинэ дэд төвийг барих төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар нийслэл Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, төвлөрлийг сааруулах, түгжрэлийг бууруулах, хот байгуулалт, барилгын хөгжилд бодитой хувь нэмэр оруулах зорилгоор Чингэлтэй дүүргийн 14, 18 дугаар хороо, Сүхбаатар дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэр нийт 158 га талбайд гэр хорооллыг орон сууцжуулах төслийн үйл ажиллагааг зохион байгуулахыг “Сэлбэ хорин минутын хот корпорац” ХХК (Э.Одонтуяа)-д даалгасугай.

2.Захирамжийн 1-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай “Сэлбэ хорин минутын хот корпорац” ХХК-ийн дүрмийн сангийн хөрөнгөд зориулах 3,000,000,000 (гурван тэрбум) төгрөгийг Нийслэлийн 2025 оны төсөвт тусгагдсан холбогдох зардлаас санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Л.Эрдэнэбадрах)-т зөвшөөрсүгэй.

3.Энэхүү захирамжийн 2 дугаар зүйлд заасан санхүүжилт, зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Х.НЯМБААТАР



1110200194

